



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон сумын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021 /52/-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580

Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716

Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: П.Содном

Утас: 70342495

Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	Error! Bookmark not defined.
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	Error! Bookmark not defined.
3. Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж.....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	Error! Bookmark not defined.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.04.25 № 46

Танай _____-ны № _____-т

**ОРХОН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА**

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

0000000

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ДАНХБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	62,248,501.33	68,232,839.19
33	АВЛАГА	1,345,206.01	2.23
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	888,306.01	2.23
335	Бусад авлага	456,900.00	-
3351	Байгууллагаас авах авлага	456,900.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	60,903,295.32	68,232,836.96
351	Түүхий эд материал	692,800.00	1,583,132.43
35110	Тусгай зориулалттай материал	663,400.00	1,551,632.43
35130	Эм боох материал	29,400.00	31,500.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,339,020.00	1,121,880.00
354	Хангамжийн материал	56,871,475.32	65,527,824.53
35410	Бичиг хэргийн материал	292,300.00	536,600.00
35420	Аж ахуйн материал	326,922.00	754,272.00
35430	Сэлбэг хэрэгсэл	46,000.00	46,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	-
35450	Барилгын засварын материал	628,500.00	2,553,000.00
35460	Хүнсний материал	6,431,146.30	486,823.70
35470	Бусад хангамжийн материал	49,146,607.02	61,151,128.83
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	393,063,156.42	271,838,092.21
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	393,063,156.42	271,838,092.21
392	Биет хөрөнгө	370,343,072.92	247,915,508.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	445,183,155.93	450,350,601.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	(144,352,565.42)	(287,895,763.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	3,500,000.00	3,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(3,500,000.00)	(3,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	96,086,407.90	59,095,809.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(84,057,929.73)	(26,600,208.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	67,404,657.66	60,518,117.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	(33,585,471.36)	(22,513,642.91)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,957,937.00	11,910,433.00

39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,514,682.84)	(7,256,402.04)
39217	Ном	10,221,563.78	10,306,563.78
393	Биет бус хөрөнгө	22,720,083.50	23,922,583.58
39301	Програм хангамж	1,250,000.00	2,600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(597,916.50)	(745,416.42)
39303	Бусад биет бус хөрөнгө	22,068,000.00	22,068,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>455,311,657.75</u>	<u>340,070,931.40</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>1,821,954.10</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,821,954.10
413	Өглөг	-	1,821,954.10
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,821,954.10
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>455,311,657.75</u>	<u>338,248,977.30</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	455,311,657.75	338,248,977.30
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	290,346,764.02	290,346,764.02
51101	Өмч: - төрийн	290,346,764.02	290,346,764.02
512	Хуримтлагдсан үр дүн	(297,756,804.61)	(414,819,485.06)
51210	Өмнөх үеийн үр дүн	(297,756,804.61)	(297,756,804.61)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(117,062,680.45)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	462,721,698.34	462,721,698.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>455,311,657.75</u>	<u>340,070,931.40</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	542,532,900.00	614,684,122.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,455,800.00	43,446,722.24
120	Нийтлэг татварын бус орлого	11,455,800.00	43,446,722.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,792,400.00	36,171,801.91
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,792,400.00	36,171,801.91
120009	Бусад орлого	663,400.00	
120018	Үнэ төлбөргүй авсан орлого- Бараа материал		7,274,920.33
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	531,077,100.00	571,237,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	443,750,100.00	488,293,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	443,750,100.00	488,293,000.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,200,200.00	597,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,200,200.00	597,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	85,926,800.00	82,347,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	85,926,800.00	82,347,200.00
1330	Төсвийн захирагчдаас	200,000.00	-
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	200,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	670,274,386.08	724,168,822.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	670,274,386.08	724,168,822.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	649,657,111.12	689,871,314.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	315,408,265.39	378,014,823.10
210101	Үндсэн цалин	234,558,083.39	272,631,008.10
210102	Нэмэгдэл	40,409,224.00	60,686,634.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	40,440,958.00	44,697,181.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,537,956.64	47,780,364.18
210201	Тэтгэврийн даатгал	26,853,713.93	32,642,737.11
210202	Тэтгэмжийн даатгал	3,187,859.70	3,832,759.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,532,367.78	3,089,475.04
210204	Ажилгүйдлийн даатгал	633,095.83	745,113.80
210205	Эрүүл мэндийн даатгал	6,330,919.40	7,470,278.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,679,137.00	81,210,315.00
210301	Гэрэл, цахилгаан	4,789,481.00	3,008,289.00
210302	Түлш, халаалт	84,306,656.00	77,632,526.00
210303	Цэвэр, бохир ус	583,000.00	569,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,612,204.00	4,397,698.00
210401	Бичиг хэрэг	957,450.00	364,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,004,400.00	895,470.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	272,000.00	280,000.00
210404	Ном, хэвлэл	17,200.00	597,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	824,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,361,154.00	1,436,828.00
2105	Нормативт зардал	24,509,290.24	15,408,185.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	132,800.00	641,650.00

210502	Хоол, хүнс	24,376,490.24	14,270,535.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	496,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,706,250.00	488,500.00
210604	Урсгал засвар	5,706,250.00	488,500.00
2107	Томилолт, зочны зардал	89,600.00	155,200.00
210702	Дотоод албан томилолт	89,600.00	155,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	244,700.00	714,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	172,700.00	390,550.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	72,000.00	324,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	165,869,707.85	161,701,678.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	120,200.00	1,807,478.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,880,050.00	1,207,377.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	163,869,457.85	158,686,823.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,617,274.96	34,297,508.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,709,200.00	5,789,792.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,974,200.00	5,289,940.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	735,000.00	499,852.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,908,074.96	28,507,716.20
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,908,074.96	28,507,716.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(127,741,486.08)	(109,484,700.04)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,046,000.00	7,577,980.41
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	66,000.00	7,577,980.41
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	3,980,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(4,046,000.00)	(7,577,980.41)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(131,787,486.08)	(117,062,680.45)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	544,967,565.00	571,694,300.00
141001	Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	544,967,565.00	571,694,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	443,750,100.00	488,293,000.00

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	443,750,100.00	488,293,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
		15,090,665.00	1,054,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,090,665.00	1,054,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		
		85,926,800.00	82,347,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	85,926,800.00	82,347,200.00
1330	Төсвийн захирагчдаас		
		200,000.00	-
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	200,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	531,008,765.00	561,379,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	531,008,765.00	561,379,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	507,333,060.04	529,298,931.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		
		315,543,862.00	375,304,562.39
210101	Үндсэн цалин	227,623,433.00	270,514,666.00
210102	Нэмэгдэл	53,449,474.00	76,985,836.39
210104	Урамшуулал	34,470,955.00	27,804,060.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		
		40,180,861.04	47,780,367.01
210201	Тэтгэврийн даатгал	27,249,835.44	30,774,816.71
210202	Тэтгэмжийн даатгал	3,305,984.20	5,767,097.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,579,348.82	3,025,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	644,862.19	650,152.54
210205	Эрүүл мэндийн даатгал	6,400,830.39	7,563,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		
		89,679,137.00	81,210,315.00
210301	Гэрэл, цахилгаан	4,789,481.00	3,008,289.00
210302	Түлш, халаалт	84,306,656.00	77,632,526.00
210303	Цэвэр, бохир ус	583,000.00	569,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
		9,057,900.00	6,350,970.00
210401	Бичиг хэрэг	180,000.00	187,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,644,400.00	895,470.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	272,000.00	280,000.00
210404	Ном, хэвлэл	149,200.00	597,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	147,400.00	1,680,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,664,900.00	2,710,800.00
2105	Нормативт зардал		
		29,866,600.00	9,268,012.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	132,000.00	126,750.00
210502	Хоол, хүнс	29,079,700.00	8,326,212.40

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	654,900.00	815,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,306,000.00	794,478.00
210604	Урсгал засвар	13,306,000.00	794,478.00
2107	Томилолт, зочны зардал	89,600.00	155,200.00
210702	Дотоод албан томилолт	89,600.00	155,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	244,700.00	714,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	172,700.00	390,550.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	72,000.00	324,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,364,400.00	7,720,477.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,928,400.00	5,919,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,436,000.00	1,800,577.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,675,704.96	32,080,368.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,310,730.00	3,572,652.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,575,730.00	3,072,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	735,000.00	499,852.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,364,974.96	28,507,716.20
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,364,974.96	28,507,716.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	13,958,800.00	10,315,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,758,800.00	10,315,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,758,800.00	10,315,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,758,800.00	10,315,000.00
222001	Тоног төхөөрөмж	13,758,800.00	10,315,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(13,758,800.00)	(10,315,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	290,346,764.02	462,721,698.34	(297,756,804.61)	455,311,657.75
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-

C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	290,346,764.02	462,721,698.34	(297,756,804.61)	455,311,657.75
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	290,346,764.02	462,721,698.34	(297,756,804.61)	455,311,657.75
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	290,346,764.02	462,721,698.34	(297,756,804.61)	455,311,657.75
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	290,346,764.02	462,721,698.34	(297,756,804.61)	455,311,657.75
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(117,062,680.45)	(117,062,680.45)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	290,346,764.02	462,721,698.34	(414,819,485.06)	338,248,977.30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	575988800.00	542102483.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	575988800.00	542102483.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	564319600.00	538529831.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	375718700.00	375304562.39
210101	Үндсэн цалин	269292800.00	270514666.00
210102	Нэмэгдэл	64302200.00	76985836.39
210104	Урамшуулал	42123700.00	27804060.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49701000.00	47780367.01
210201	Тэтгэврийн даатгал	34574800.00	30774816.71
210202	Тэтгэмжийн даатгал	3781600.00	5767097.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	3025200.00	3025200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	756300.00	650152.54
210205	Эрүүл мэндийн даатгал	7563100.00	7563100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86889800.00	81210315.00
210301	Гэрэл, цахилгаан	6000000.00	3008289.00
210302	Түлш, халаалт	80306800.00	77632526.00
210303	Цэвэр, бохир ус	583000.00	569500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8921800.00	7714270.00
210401	Бичиг хэрэг	189000.00	187000.00
210402	Тээвэр, шатахуун	1850000.00	895470.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	309,600.00	280,000.00
210404	Ном, хэвлэл	171,600.00	55,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,737,000.00	1,680,500.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,664,600.00	4,616,300.00
2105	Нормативт зардал	25,086,400.00	9,268,012.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	128,800.00	126,750.00
210502	Хоол, хүнс	24,142,400.00	8,326,212.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	815,200.00	815,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	806,000.00	794,478.00
210604	Урсгал засвар	806,000.00	794,478.00
2107	Томилолт, зочны зардал	615,200.00	155,200.00
210702	Дотоод албан томилолт	615,200.00	155,200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,155,700.00	8,059,050.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,481,700.00	6,385,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	1,350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,425,000.00	8,243,577.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,625,000.00	5,463,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,800,000.00	2,780,577.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,669,200.00	3,572,652.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,669,200.00	3,572,652.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,969,200.00	3,072,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	499,852.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	575,988,800.00	542,132,483.80
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	488,293,000.00	459,785,283.80
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	488,293,000.00	459,785,283.80
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	87,695,800.00	82,347,200.00
132001	Орон нутгийн төсвөөс	87,695,800.00	82,347,200.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32.00	32.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ц.Оюун-Эрдэнэ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор хариуцаж хэрэгжүүлэв.

2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг булган аймаг адхь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 22-ний өдрийн 01/03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Ерөнхий боловсролын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бага боловсрол
- Дунд боловсрол
- Бүрэн дунд боловсрол

Аймгийн Засаг даргын Хөгжлийн хөтөч, Оюунлаг Булган, Амжилтын галт тэрэг, Эрүүл ирээдүй, Хүүхэд залуучуудад экологийн боловсрол олгох хөтөлбөр, боловсрол хөтөлбөр"-үүд хэрэгжүүлэх хүрээнд 3 заалт 36 арга хэмжээний, биелэлтийг жилд 2 удаа хагас бүтэн жилээр тооцон биелэлтийг гарган хүргүүлж 94.2 хувьтай байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүүгийн хяналт дотоод аудитын газар 2020 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны тайлангийн 674296.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 13485.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны үр дүнгийн нийт зардлаас төлөвлөлтийн үе шатанд сонгосон 2 хувиар буюу 14634.9 мянган төгрөгөөр сонголоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 115240.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	1345.2	0.0	-1345.2
Урьдчилгаа			
Бараа материал	60903.3	68232.8	7329.5
Үндсэн хөрөнгө	393063.2	271838.1	121225.1
Нийт хөрөнгө	455311.7	340070.9	-115240.7
Өр төлбөр	0	1821.9	1821.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	455311.7	3338248.9	-117062.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	455311.7	340070.9	115240.7

Авлага дансны эхний үлдэгдэл НДШ-ийн 592.9, ХХОАТ-ын 295.4, байгууллагаас авах авлагын 456.9 нийт 1345.2 мянган төгрөгийг тайлант онд барагдуулж жилийн эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 68232.8 мянган төгрөг болж 7329.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны төсвийн худалдан авалт, үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгөөс шалтгаалжээ.

Бараа материалын дансанд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 24006.2, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 8721.9 мянган төгрөг хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Бараа материалын худалдан зарцуулсан 25398.6 мянган төгрөгөөр хасагдсан байна. Нийт бараа материалын 89.6 буюу 61151.1 мянган төгрөгийн бусад хангамжийн материал эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 620349.5 мянган төгрөг болж 43322.2 мянган төгрөгөөр буурсан нь акталсан 18947.8, шилжүүлсэн 6386.7, бусад 60812.1 нийт 86146.5 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсанаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтаар 10350.0, хандиваар 359.9, шилжүүлэн авсан 3586.3, байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 607071.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 607071.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 95501.1 мянган төгрөгөөр бууруулж 511570.3 мянган төгрөгөөр баталсан байна. Өмнөх оны төсвөөс цалинг 115971.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн төсөл хийсэн нь төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, шатлал ахих болон цалингийн нэмэгдүүлэхээр тооцжээ.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх, хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 511570.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 486201.1 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс 25369.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс тогтмол зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 507967.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 21390.2 мянган төгрөгийн нийт 529357.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 476082.2 мянган төгрөгийг зарцуулж 53275.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 476082.2 мянган төгрөг буюу 93.7 хувьтай байгаа нь цалингийн зардал 31086.7, тогтмол зардлыг 3478.5, норматив зардлаас хүнс 18041.5, үдийн цай 9991.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт санхүүжилтийн 520.0 мянга төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хашааны хаалганы төмөрт 423.0, Шагжийн хөрөг хийх жаазыг 73.0 нийт 520.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 272 мэдээллээс хугацаандаа оруулсан 272 мэдээлэл оруулж цахим хуудсанд бүрэн хөтөлсөн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2331.9 мянган төгрөгийн зөрчилд 312.8 мянган төгрөгийн төлбөрийн акт, 891.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1127.9 мянган төгрөгийн албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 891.2 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	312.8	1	312.8			
Албан шаардлага	1	1127.9	1	1127.9			
Зөвлөмж	1	891.2	1	891.2			
Нийт дүн	3	2331.9	3	2331.9			

/мянган.төг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9180.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 121.6 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 7780.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1350.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 7830.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 121.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 7708.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Хичээл үйлдвэрлэлийн зардлаас тоног төхөөрөмж, хөрөнгө бэлтгэх 4989080, урсгал засварт 2719900, зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

2. БСУГ-ын даргын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/317 дугаар албан бичгийн үндэслэн захирал Х.Тамжид 121657 төгрөгийн улирлын үр дүнгийн урамшууллыг авсан нь Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх "Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн үр дүнгийн гэрээг дүгнэх эрх бүхий этгээд нь дараах арга хэмжээг авна:", 40.4.2 дахь "хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд урамшуулах, хариуцлага тооцох", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 1.2.1. "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид;" заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1350 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Удирдлагатай холбоотой асуудал

1. Илрүүлэлт: Байгууллагын дотоод журмыг байгууллагын даргын 2018 онд баталсныг Төрийн албаны болон бусад хууль тогтоомж шинэчлэн гарсантай холбоотой өөрчлөлтүүд хийгээгүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх "Ажил олгогч нь ажилтны төлөөлөгчдийн саналыг харгалзан хөдөлмөрийн дотоод журмыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж мөрдүүлнэ." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.1. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх

1.2. Өгсөн зөвлөмж: Байгууллагын дотоод журмыг Төрийн албаны болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн шинэчлэн батлуулах.

1.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Мэдээлэл технологийн зардлаас Нягтлан бодох бүртгэлийн программын хөгжүүлэлт хийгдэх 4 жилийн гэрээний дагуу 1350.0 мянган төгрөгийн программ хангамжийг орлогоор бүртгээгүй.

2.2. Эрсдэл: Хөрөнгө дутагдах, хууль журам зөрчилдөх.

2.3. Өгсөн зөвлөмж: Үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, бараа материалыг анхан шатны баримтад үндэслэн хөдлөл, өөрчлөлтийг тухай бүр хийж, байх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

П.СОДНОМ